



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТЭЭС...

АУДИТАД
ХАМРАГДСАН
ДУУСААГҮЙ
БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИЙН
ТОО


46



АЙМГУУДАД



НИЙСЛЭЛД



АУДИТАД
СОНГОГДСОН
ШАЛГУУР

1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 оноос хойш баригдаж эхэлсэн боловч санхүүжилт нь зогссон

2

Гурав, түүнээс дээш жил үргэлжилж байгаа, барилга угсралтын ажил нь дуусаагүй, ашиглалтад оруулаагүй

ДУУСААГҮЙ, ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН АНГИЛАЛ, ТОО

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН БАГЦААС

Сургуулийн барилга, спорт заал: 3

Спорт цогцолбор, усан бассейн: 5

Соёлын төв: 2

Театр, чуулгын барилга: 2

Усан оргилуур: 1

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН БАГЦААС

Цахилгаан дамжуулах агаарын шугам: 2

Дулааны шугамын барилга: 3

Хаалттай хуваарилах байгууламж: 1

ТӨСВИЙН БУСАД ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БАГЦААС

Эмнэлгийн барилга: 2

Хог боловсруулах үйлдвэр: 1

Хүүхдийн зуслангийн соёлын төвийн барилга: 1

Авто зам: 1

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр: 1

Ахмадын сувиллын өргөжилтийн барилга: 1

Олон улсын худалдааны төвийн барилга: 1

Шүүхийн нэгдсэн байр: 1

Засаг даргын тамгын газрын контор: 1

Прокурорын нэгдсэн байр: 1

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН БАГЦААС

Инженерийн шугам сүлжээ: 7

Сумын төвийн шинэчлэл төсөл: 7

Лабораторийн барилга: 1

Үйлчилгээний төвийн барилга: 1

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙГ ДУУСГААГҮЙ
ОРХИСОН ГОЛ ШАЛТГААН



Батлагдсан зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгасан.




АУДИТЫН ДҮНД ҮНДЭСЛЭН ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖУУДЫГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ДУУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

ДУУСААГҮЙ, ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН САНХҮҮЖИЛТ



АУДИТАД ХАМРАГДСАН
НИЙТ **46** БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИЙН
ТӨСӨВТ ӨРТӨГ БА
САНХҮҮЖИЛТ



225.4
ТЭРБУМ ТӨГРӨГ
(төсөвт өртөг)



141.4
ТЭРБУМ ТӨГРӨГ
(олгосон санхүүжилт)

ДЭЭРХ 46 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖААС 39 НЬ ҮРГЭЛЖЛЭН БАРИГДАЖ,
АШИГЛАЛТАД ОРОХ БОЛОМЖТОЙ.



39

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ
(үргэлжлүүлэн барьж,
ашиглалтад оруулах
боломжтой)



7

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ
(тодорхой асуудлыг
шийдвэрлэх хүртэл
үргэлжлүүлэх боломжгүй)

36

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ
(2019 оны төсвийн тухай
хуульд үргэлжлүүлэхээр
тусгагдаагүй)

120.1

ТЭРБУМ ТӨГРӨГ
(Дээрх 36 төсөлд 2019
оноос өмнө олгосон нийт
санхүүжилт)



Дуусаагүй орхигдсон 36 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгаагүй, цаашид хэрхэх нь ч тодорхойгүй байна. Энэ нь эдгээр төсөлд олгосон 120.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг буурах, барилга, байгууламжийн нийгмийн ач холбогдол, хэрэгцээ, шаардлага алдагдах, чанар муудах, эзэнгүйдэх эрсдэлийг дагуулж байна.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОЙМ (ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДААР)

Барилга, хот байгуулалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын болон Эрчим хүчний сайд нарын төсөл, арга хэмжээ

76%

Төсвийн бусад ерөнхийлөн захирагч

24%

Дуусгаагүй орхигдсон төсөл, арга хэмжээг дуусгах талаар төсвийн ерөнхийлөн захирагч нар дорвитой арга хэмжээ авч ажиллаагүй байна.

ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ (ТЭРБУМ ТӨГРӨГ)	
		ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ	
 Барилга, хот байгуулалтын сайд	16	62.8	47.5
 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	13	28.9	21.0
 Эрчим хүчний сайд	6	63.9	55.5
 Шүүхийн ерөнхий зөвлөл	1	36	5
 Улсын ерөнхий прокурор	1	16	2.4
 Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	10	5.7
 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2	2.9	1
 Эрүүл мэндийн сайд	2	2.5	2
 Засгийн газрын хэрэг эрхлэх газар	1	1	0.2
 Зам тээврийн хөгжлийн сайд	1	0.9	0.7
 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	1	0.4	0.3
 Батлан хамгаалахын сайд	1	0.2	0.1



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018


ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДАД ОЛГОСОН ИЛҮҮ САНХҮҮЖИЛТ



ДУУСААГҮЙ ОРХИГДСОН
28 БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИД ИЛҮҮ
ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ


19.2
ТЭРБУМ ТӨГРӨГ

Төсвийн бусад
ерөнхийлөн
захирагч



Боловсрол, соёл,
шинжлэх ухаан,
спортын сайд

Эрчим хүчний
сайд



тэрбум төгрөг

Барилга, хот
байгуулалтын
сайд

САНХҮҮЖИЛТИЙГ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРААР ХАРУУЛБАЛ:

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО	ИЛҮҮ ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ (ТЭРБУМ ТӨГРӨГ)
Барилга, хот байгуулалтын сайд	9	7.32
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	8	3.75
Эрчим хүчний сайд	2	3.01
Шүүхийн ерөнхий зөвлөл	1	1.83
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	1	1.76
Эрүүл мэндийн сайд	2	0.72
Улсын Ерөнхий Прокурор	1	0.36
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1	0.22
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	1	0.10
Зам, тээврийн хөгжлийн сайд	1	0.10
Батлан хамгаалахын сайд	1	0.06
Нийт дүн	28	19.23



ИЛҮҮ ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН 13.6 ХУВЬ НЬ ҮР АШИГГҮЙ ЗАРЦУУЛАГДСАН БАЙХАД ХАРИУЦЛАГА АЛДСАН АЛБАН ТУШААЛТАНД АРГА ХЭМЖЭЭ АВАЛГҮЙ ӨНӨӨГ ХҮРЧЭЭ.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ӨГЧ БҮЙ ЗӨВЛӨМЖ



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНД:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, Барилгын тухай хуулийн дагуу төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгасан төсвийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж байх чиглэлийг Засгийн газарт өгөх;
- Төсвийн тухай хууль зөрчин шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний төслийг УИХ-д өргөн барьсан Засгийн газар, Төсвийн ерөнхийлөн захирагч нартай хариуцлага тооцож байхаар зохих хуульд нэмэлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх.



САНГИЙН САЙДАД:

- Дуусаагүй орхигдсон барилга, байгууламжийн ажлыг бодит гүйцэтгэлээр үнэлж, баталгаажуулаагүй илүү олгосон санхүүжилтийг төсөл, арга хэмжээ бүрээр нарийвчлан шалгаж, буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох;
- Захиалагчийн хяналт хангалтгүйгээс барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт авсан, гүйцэтгэл дутуу, санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан гүйцэтгэгчийн мэдээллийг ил тод болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, цаашид бодит ажлын гүйцэтгэлээр санхүүжилт олгох хууль, тогтоомжийн заалтыг чанд мөрдүүлэх арга хэмжээ авах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга, байгууламжийн угсралтын ажлыг хангалтгүй гүйцэтгэж ирсэн байгууллага, аж ахуйн нэгжийн нэрийг “Хар жагсаалт”-д оруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагаанд оролцуулахгүй байх арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн авч хэрэгжүүлэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналтыг сайжруулах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, таслан зогсоох албан даалгавар гаргаж хэрэгжилтийг хангуулах.



ЗАСГИЙН ГАЗАРТ:

- Дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ бүрээр гаргасан аудитын дүгнэлтийг үндэслэн илэрсэн зөрчлийг арилгах, төсөл, арга хэмжээг цаашид хэрхэх талаар гаргасан мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон хэрэгцээ шаардлагыг үндэслэн шийдвэрлэх ажлын хэсэг байгуулан ажиллуулах;
- Дуусаагүй орхигдсон арга хэмжээ бүрээр төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналд хариуцлага алдсан байгууллага, албан тушаалтантай хариуцлага тооцох;
- Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн төсөл, арга хэмжээ дуусаагүй орхигдох боломжгүй байхаар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төсөвлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэх;
- Ажил гүйцэтгэх гэрээний жишиг баримт бичигт холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, норматив, стандарт, техникийн тодорхойлолт, зураг, төсвийн дагуу ажлыг гүйцэтгэх, талууд ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дуусах бүрд гэрээг дүгнэж, үр дүнг тооцож байх зэрэг нэмэлт, өөрчлөлт оруулах, жишиг гэрээний загварыг батлах эрх бүхий этгээдийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Барилгын тухай хуулиудад байгаа давхардлыг арилгах асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэх.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ ӨГЧ БҮЙ ЗӨВЛӨМЖ


1. Барилга угсралтын ажлын хэрэгжилт хангалтгүй дуусаагүй барилга байгууламж, төсөл, арга хэмжээг анхны төсөвт өртөгт багтаан гүйцэтгэлийг хангуулах зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах;
2. Санхүүжилт батлагдаагүйгээс он дамжин дуусаагүй орхигдсон ч үргэлжлүүлэх боломжтой барилга, байгууламжийн үлдэгдэл санхүүжилтийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;
3. Дуусаагүй, орхигдсоноос үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон барилга байгууламжийн зориулалт, барилгын ажлын чанар байдлыг нягтлан үзэж, цаашид хэрхэн ашиглах талаар санал боловсруулж холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжих, ашиглалтад оруулах хугацаа, санхүүжилтийн хэрэгцээ шаардлагыг оновчтой, зөв тооцож төлөвлөх, төсвийн хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагыг мөрдөж ажиллах;
5. Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон, гэрээний үүргээ хэрэгжүүлэлгүй барилга, байгууламжийн угсралтын ажлыг дутуу орхиж улсад их хэмжээний хохирол учруулсан албан тушаалтан, холбогдох байгууллагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж хохирлыг барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
6. Тайланд дурдагдсан төсөл, арга хэмжээ бүрээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны эхний хагас жилд багтаан ирүүлэх.





УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

АЙМГУУД ДАХЬ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОЙМ



67.7

ТЭРБУМ ТӨГРӨГ
(нийт төсөвт өртөг)



48.2

ТЭРБУМ ТӨГРӨГ
(олгосон санхүүжилт)

АЙМАГ ТУС БҮРЭЭР



ДОРНОГОВЬ, ХЭНТИЙ АЙМГУУДАД ӨНДӨР ӨРТӨГТЭЙ БҮЮУ
НИЙТ 26.8 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖ БАЙНА.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН
БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018












**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН
БАГЦАД ХАМААРАХ, АЙМГУУД ДАХЬ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ**



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

ЕСӨН АЙМАГ ДАХЬ 11 БАРИЛГА
БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТЫН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ НЬ 15-85 ХУВЬТАЙ БАЙНА.

(тэрбум төгрөг)

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ		БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (ХУВЬ)
		МӨНГӨН ДҮН	ХУВЬ	
 Хан Хэнтий чуулгын барилга (Хэнтий, Хэрлэн сум)	8.4	8.2	100%	80%
 Төв халхын дуулалт жүжгийн театрын барилга (Дундговь, Сайнцагаан сум)	6.8	2.0	30%	15%
 Хүүхэд залуучуудын соёл үйлчилгээний цогцолбор, усан бассейн (Архангай, Эрдэнэбулган сум)	1.8	1.5	88%	85%
 Спорт цогцолборын барилга, 700 хүний суудалтай (Сүхбаатар, Баруун-Урт сум)	1.6	1.2	74.9%	35%
 Соёлын төв, захирагчийн албаны барилга (Сэлэнгэ аймаг, Орхонтуул сум)	1.5	1.6	104.3%	80%
 Спорт цогцолбор (Дорноговь, Хатанбулаг)	0.91	0.87	94.9%	80%
 Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн (Дорнод, Хэрлэн сум)	0.91	0.38	21.7%	20%
 Спорт цогцолбор, усан бассейн, 700 хүний суудалтай (Баянхонгор, Баянхонгор сум)	0.9	0.81	90.1%	30%
 Соёлын төвийн барилга, 250 хүний суудалтай (Баянхонгор, Бууцагаан сум)	0.66	0.25	29%	20%
 Бага сургуулийн шинэ барилга (Баянхонгор, Бууцагаан сум)	0.5	0.48	50.6%	30%
 Соёл амралтын хүрээлэн байгуулах, багц 3-усан оргилуур, усан хангамжийн ажил (Говь-Алтай)	0.18	0.1	56.8%	80%



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН
БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018











**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН БАГЦАД ХАМААРАХ,
АЙМГУУД ДАХЬ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭЛЭЛ**



БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

НАЙМАН АЙМАГ ДАХЬ 10 БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТЫН АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛ НЬ 47-90 ХУВЬТАЙ БАЙНА.


(тэрбум төгрөг)

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ		БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (ХУВЬ)
		МӨНГӨН ДҮН	ХУВЬ	
 Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх соёл, спортын цогцолборын барилга, 700 хүний суудалтай (Дорноговь, Замын-Үүд сум)	5.8	2.7	45.7%	47%
 Сумын төвийн шинэчлэл (Сүхбаатар, Эрдэнэцагаан)	5.0	4.4	87.8%	85%
 Сумын төвийн шинэчлэл төсөл (Дорнод, Баян-Уул)	5.0	4.0	80.2%	90%
 Сумын төвийн шинэчлэл төсөл (Хэнтий, Биндэр сум)	5.0	4.6	92%	90%
 Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ баригдах 800 айлын цэвэр усан хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил (Хөвсгөл, Мөрөн)	5.0	4.0	80%	71%
 Сумын төвийн шинэчлэл төсөл (Говь- Алтай, Дэлгэр сум)	5.0	3.5	70%	49%
 Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх эмнэлгийн барилга, 100 ортой (Дорноговь, Замын-Үүд сум)	5.0	3.4	84.4%	81%
 Барилгын материалын лабораторийн барилга (Өмнөговь, Даланзадгад сум)	1.0	0.94	94.3%	85%
 Гэр хорооллын бохир усны 2.4 км шугам (Сэлэнгэ, Сайхан сум)	0.27	0.24	98.7%	79.2%
 Үйлчилгээний төвийн барилга (Сэлэнгэ, Ерөө сум)	0.25	0.25	100.2%	50%



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

ТӨСВИЙН БУСАД ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БАГЦАД ХАМААРАХ, АЙМГУУД ДАХЬ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД БОЛОН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДААС БУСАД ЗУРГААН САЙДЫН БАГЦАД ХАМААРАХ ТУС БҮР НЭГ ДУУСААГҮЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ НЬ 5-60 ХУВЬТАЙ БАЙНА.

(тэрбум төгрөг)

БАРИЛГА БАЙГУУЛАМЖ	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ		БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ
			МӨНГӨН ДҮН	ХУВЬ	
Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр (Орхон, Баян-Өндөр сум)	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2.2	0.19	8.6%	5%
Төрөх эмнэлэг 50 ортой (Дорноговь, Сайншанд)	Эрүүл мэндийн сайд	1.7	1.3	100%	50%
ЗДТГ-ын контор (Завхан, Их-Уул сум)	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	0.97	0.22	22.7%	25%
Аймгийн төвийн 2 км автозам (Баянхонгор, Баянхонгор сум)	Зам тээврийн хөгжлийн сайд	0.91	0.68	75%	60%
“Боршоо” Олон улсын худалдааны төвийн барилга угсралтын ажил (Увс, Давст сум)	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	0.4	0.27	67.9%	30%
Шонхор хүүхдийн зуслангийн Соёлын төвийн барилга (Сэлэнгэ аймаг, Мандал сум)	Батлан хамгаалахын сайд	0.16	0.13	81.2%	35%




ДЭЭРХ ЗУРГААН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХУВЬД ХАМГИЙН ӨНДӨР ТӨСӨВТЭЙ ТӨСӨЛ НЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН БАГЦЫН ОРХОН АЙМАГТ БАЙРШИЛТАЙ ХӨДӨӨ АЖ АХУЙН МСҮТ-ИЙН ХИЧЭЭЛИЙН БАЙР БАЙНА.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

НИЙСЛЭЛД БАЙРШИЛТАЙ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОЙМ

Нийслэлд нийт 93.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон 19 дуусаагүй орхигдсон барилга, байгууламж байна.



19 БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖ



157.6

ТЭРБУМ ТӨГРӨГ
(нийт төсөвт өртөг)



93.2

ТЭРБУМ ТӨГРӨГ
(олгосон санхүүжилт)

НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БАЙРШИЛТАЙ ДУУСААГҮЙ, ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО, ТӨСӨВТ ӨРТӨГ, САНХҮҮЖИЛТ

(тэрбум төгрөг)

	БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ
Хан-Уул дүүрэг	2	52.0	7.4
Нийслэл	8	65.7	54.8
Баянзүрх дүүрэг	3	14.0	9.3
Баянгол дүүрэг	1	17.0	15.2
Сонгинохайрхан дүүрэг	3	6.6	5.0
Чингэлтэй дүүрэг	1	1.6	0.8
Сүхбаатар дүүрэг	1	0.71	0.79



НИЙТ ТӨСӨВТ ӨРТГИЙН 33 ХУВЬ БҮЮУ 52 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ
НЬ ХАН-УУЛ ДҮҮРЭГТ БАЙРШИЖ БАЙНА.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР
САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН
БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

**НИЙСЛЭЛД БАЙРШИЛТАЙ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БОЛОН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДУУДЫН БАГЦ**

(тэрбум төгрөг)

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ		БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (ХУВЬ)
		МӨНГӨН ДҮН	ХУВЬ	
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН БАГЦ				
Сургуулийн барилга, 640 суудалтай (УБ, БЗД, 11-р хороо, 126 дугаар сургууль)	3.3	2.8	86%	90%
Спорт заалны барилга (61 дүгээр сургууль, УБ, ЧД)	1.6	0.8	73.6%	30%
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН БАГЦ				
Улаанбаатар хотын бохир усны Туул-1 коллекторын шугам угсралтын ажил	13.7	12.2	94.6%	65%
Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажил (30-р хороо, Хилчин хотхон, УБ, СХД)	5.0	4.5	90%	40%
14-р хорооллын ус дулаан дамжуулах төв 4ш, ф200/300мм-ийн 1134 метр, ф125/250мм 2239 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил	3.5	1.9	54%	54%
14-р хорооллын бохир усны ф200/300мм-ийн 1128 метр, ф300мм-ийн 1185 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил, Цэвэр усны ф150-250мм-ийн 2103 метр, ф125/200мм-ийн 1065 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	1.60	0.39	49.8%	50%
СХД-ийн 10-р хороо, Усан хангамж ф32/150мм-ийн 871 метр шугам, ариутгах татуургын ф300мм-ийн голчтой 1246 метр шугамын угсралтын ажил	0.86	0.27	31.5%	20%
СХД-ийн 10-р хороо, Дулааны ф65/200мм-ийн голчтой 924 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил	0.75	0.23	30%	0%



- Дээрх хоёр төсвийн ерөнхийлөн захирагчийн багц дахь дуусаагүй, орхигдсон хамгийн өндөр төсөвтэй барилга нь Улаанбаатар хотын бохир усны Туул-1 коллекторын шугам угсралтын ажил (13.7 тэрбум төгрөг) байна.
- Сонгинохайрхан дүүргийн 10-р хорооны дулааны шугамын барилга угсралтын ажилд 30 хувийн санхүүжилт олгогдсон боловч ажлын гүйцэтгэл 0 хувь байна.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

НИЙСЛЭЛД БАЙРШИЛТАЙ ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА (ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДААР)

(тэрбум төгрөг)

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ		БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (ХУВЬ)
		МӨНГӨН ДҮН	ХУВЬ	
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН БАГЦ				
Сонгино 220/110/35кВ-ын 2*125МВа дэд станц, 220кВ-ын 10км цахилгаан дамжуулах агаарын шугам	19.5	17.0	93.5%	90%
Дулааны цахилгаан станц 4-өөс Москва хорооллын урд тал хүртэлх 4.2км, ф800-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил (УБ, БГД)	17.0	15.2	89.3%	78%
Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил	9.3	8.5	92.1%	77%
220кВ-ын Сонгино дэд станцаас 110кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110кВ-ын 50км, 2 хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, барилга угсралтын ажил	9.0	8.2	93.3%	90%
12а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2ф 400мм голчтой шугамыг 2ф 500мм болгон өргөтгөх, 3*500*70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт	7.3	5.8	88.9%	88%
Хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөл, 2 дугаар үе шатны ажил	1.8	0.8	57.4%	59.8%
ТӨСВИЙН БУСАД ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БАГЦ				
Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр (УБ, ХУД)	36.0	5.0	46.8%	10%
Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр (УБ, ХУД)	16.0	2.4	30.1%	15%
Хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажил (УБ, БЗД)	10.0	5.7	58.4%	27.7%
Эмнэлгийн барилга, 10 ортой (УБ, БЗД, Хонхор тосгон)	0.77	0.74	100%	90%
Сүхбаатар дүүргийн 15-р хорооны Ахмадын сувиллыг өргөтгөх өвлийн барилга байгууламж (УБ, СБД)	0.71	0.79	101.5%	73.2%



Дуусаагүй орхигдсон хамгийн өндөр төсөвтэй барилга нь Хан-Уул дүүрэгт байршилтай Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр (36 тэрбум төгрөг) байна. Уг барилгын санхүүжилтийн 46.8% олгогдсон боловч ажлын гүйцэтгэл 10% байна.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР САНХҮҮЖИГДСЭН, ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН-2018

ДУУСААГҮЙ ОРХИГДСОН, ТОДОРХОЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ХҮРТЭЛ ЦААШИД ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ БОЛОМЖГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ



7
БАРИЛГА,
БАЙГУУЛАМЖ



23.9
ТЭРБУМ ТӨГРӨГ
(нийт төсөвт өртөг)



14.5
ТЭРБУМ ТӨГРӨГ
(олгосон санхүүжилт)

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСӨВТ ӨРТӨГ	ОЛГОСОН НИЙТ САНХҮҮЖИЛТ		БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ (ХУВЬ)	ХОЙШЛУУЛАХ ШАЛТГААН
			МӨНГӨН ДҮН	ХУВЬ		
Хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажил (УБ, БЗД)	БОАЖС	10.0	5.7	58.4%	27.7%	
Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх соёл, спортын цогцолборын барилга, 700 суудалтай (Дорноговь, Замын-Үүд сум)	БХБС	5.8	2.7	45.7%	47%	Хууль, хяналтын байгууллагад шалгуулж байна.
Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажил (30-р хороо, Хилчин хотхон, УБ, СХД)	БХБС	5.0	4.5	90%	40%	
Хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөл, 2 дугаар үе шатны ажил (УБ)	ЭХС	1.8	0.8	57.4%	59.8%	Ардчиллын өргөөний барилга баригдах хүртэл
Соёлын төвийн барилга, 250 суудалтай (Баянхонгор, Бууцагаан сум)	БСШУСС	0.66	0.25	29%	20%	Хэрэгцээ, шаардлага байхгүй болсон тул зориулалтыг өөрчлөх
Бага сургуулийн шинэ барилга (Баянхонгор, Бууцагаан сум)	БСШУСС	0.50	0.48	50.6%	30%	
Соёл амралтын хүрээлэн байгуулах, багц 3-усан оргилуур, усан хангамжийн ажил (Говь-Алтай)	БСШУСС	0.18	0.10	56.8%	80%	Усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх хүртэл



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн барилга, байгууламжийг дуусгалгүй орхигдуулж олон жил царцааснаас эдийн засгийн үр ашиг буурах, нийгмийн ач холбогдол, хэрэгцээ шаардлага алдагдах, чанар муудах, эзэнгүйдэх эрсдэлийг бий болгож байна.